



1 “Богино хугацаагаар оршин суух статус”-тай иргэн

⇒ “Богино хугацаагаар оршин суух статус (**90 хоног**)”-тай иргэний оршин суух хугацааг сунгахыг зөвшөөрнө.

※ Японд амьжиргаагаа залгуулах эх үүсвэргүйгээс хэцүү нөхцөлд орсон гэж үзвэл, оршин суух статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх (долоо хоногт 28 цагийн дотор цагийн ажил хийх боломжтой)-г зөвшөөрнө. Дэлгэрэнгүйг [эндээс](#) үзнэ үү.

2 “Ур чадварын дадлагажигч”, “Тусгай үйл ажиллагаа (гадаадын барилгын ажилчин (32-р), гадаадын усан хөлөг онгоцны ажилчин (35-р))”-ны статустай иргэн

⇒ “Тусгай үйл ажиллагаа (**6 сар**·ажил хийх зөвшөөрөлтэй)”-ны виз болгож өөрчлөхийг зөвшөөрнө.

(Анхаар 1) Өмнөхтэй ижил төрлийн ажил (※) эрхлэх тохиолдолд хамаарна.

※ Хэрэв өмнөхтэй ижил төрлийн ажлын байр олж чадахгүй бол, “өмнөх ажилтай холбоотой ажил (ур чадварын дадлага хийсэн ажлын төрөл, ажилд харьяалагддаг “Шилжих боломжтой ажлын төрөл / ажлын жагсаалт” -ын хүснэгт дэх ажлын төрөл / ажил (“7 Бусад” -г оруулаагүй) дээр ажиллах боломжтой.

(Анхаар 2) “Тусгай үйл ажиллагаа (дадлагажигч (9-р), үйлдвэрийн гадаадын ажилчин (42-р))”-ны визтэй иргэн, өмнөхтэй ижил ажил эрхлэхийг хүсч байгаа бол оршин суух статусаа өөрчлөхийг зөвшөөрнө.

(Анхаар 3) “Богино хугацаагаар оршин суух” эсвэл “Тусгай үйл ажиллагаа (6 сар, ажиллах зөвшөөрөлгүй)-ний виз”-ний зөвшөөрөлтэй хүмүүс ч хамрагдах боломжтой.

(Анхаар 4) “Тусгай үйл ажиллагаа (Зуны ажил (12-р))”-ны визтэй иргэн, өмнөхтэй ижил ажил эрхлэхийг хүсч байвал “Тусгай үйл ажиллагаа (3 сар·ажил хийх зөвшөөрөлтэй)”-ны виз болгож өөрчлөхийг зөвшөөрнө.

3 “Оюутны виз”-тэй иргэн ажиллах хүсэлтэй байгаа бол

⇒ “Тусгай үйл ажиллагаа (**6 сар**·долоо хоногт 28 цагаа илүүгүй хугацаагаар цагийн ажил хийх боломжтой) -ны виз болгож өөрчлөхийг зөвшөөрнө.

※10 сарын 19-ны өдрөөс эхлэн, төгсөх цаг хугацаанаас үл хамаардаг болгож өөрчилсөн.

(Анхаар) “Богино хугацаагаар оршин суух” эсвэл “Тусгай үйл ажиллагаа (нутаг буцаж чадахгүй гацсан, ажиллах зөвшөөрөлгүй, эх орондоо харихад бэлтгэх) -ны виз”-р оршин сууж байсан хувчин гадаад оюутнууд ч хамрагдах боломжтой.

4 Бусад оршин суух статустай иргэн (Дээр дурдсан 2 ба 3-т хамрагдах иргэн ажил хийхийг хүсэхгүй байх тохиолдыг оруулаад)

⇒ Тусгай үйл ажиллагаа (**6 сар**·ажиллах зөвшөөрөлгүй)-ны виз болгож өөрчлөхийг зөвшөөрнө.

※ Японд амьжиргаагаа залгуулах эх үүсвэргүйгээс хэцүү нөхцөлд орсон гэж үзвэл, оршин суух статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх (долоо хоногт 28 цагийн дотор цагийн ажил хийх боломжтой)-г зөвшөөрнө. Дэлгэрэнгүйг [эндээс](#) үзнэ үү.

(Анхаар) Дээр дурдсан 1-с 4-н тухайд, эх орондоо буцах боломжгүй байдал үргэлжилж байвал, оршин суух хугацааг сунгуулж болно.